ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ХУВИЛБАР

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК

болон

ТИ ЭЙЧ АР ОЮУ ТОЛГОЙ ЛТД

ОЮУ ТОЛГОЙ НИДЕРЛАНД БИ.ВИ

ОЮУ ТОЛГОЙ ХХК

нарын хооронд байгуулсан

НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ГЭРЭЭ

2026 оны 9 дүгээр сарын 11-ны өдөр

БАТАЛГААТ ОРЧУУЛАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО
TRANSLATION BUREAU
ОРЧУУЛГЫН ТОВЧОО
ТУС0084 302-2 8094918
ДИ ПИ ТРАНСЛЭЙШН БЮРО ХХК

ЭНЭХҮҮ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ГЭРЭЭ (цаашид энэхүү "**Гэрээ**" гэх)-г 2026 оны 9 дүгээр сарын 11-ны өдөр дараах талуудын хооронд байгуулав. Үүнд:

(1) **"Эрдэнэс Оюу Толгой" ХХК** — Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Төрийн өмчит компани (цаашид "**ТӨК**" гэх);

(2) **Ти Эйч Ар Оюу Толгой Лтд** (хуучин нэрээр Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд) — Британийн Виржинийн Арлууд, ВэйЖи1110, Тортола, Роуд Таун, шуудангийн хайрцаг 71, Крэгмур Чэмбэрс хаягт байрлах, Британийн Виржинийн Арлуудын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид "**АйВиЭн**" гэх);

(3) **Оюу Толгой Нидерланд Би.Ви** — Нидерланд, Ротердам, 3197 КэйЭс Ботлек, Вэлплаатвиг 104 хаягт байрлах, Нидерланд Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид "**ОТН**" гэх); болон

(4) **"Оюу Толгой" ХХК** (хуучин нэрээр Айвенхоу Майнз Монголия Инк ХХК) — Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид "**Компани**" гэх).

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Энэхүү Гэрээ нь Компани, ОТН, АйВиЭн болон ТӨК нарын хооронд 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр байгуулагдаж, 2023 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээний дагуу нэмэлт, өөрчлөлт орсон Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ (цаашид "**НӨОДТХНГ**" гэх)-нд хамаарна.

2. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хэлэлцээрийн баг болон Рио Тинто групп (түүнийг төлөөлж ОТН болон АйВиЭн) нарын хооронд 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр аливаа бусад бүх эрхийг үл хөндөх нөхцөлтэйгээр хийсэн Хэлэлцээний үр дүнд НӨОДТХНГ-ний 11.3(ё) заалтын дагуу хүүгийн хувь хэмжээний зохистой байдлыг хянан үзэж, Компанийн санхүүжилтийн бүтцийг харгалзан үзсэний үндсэн дээр зарчмын хувьд бууруулахаар тохиролцсон болно.

3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 68 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг болон Рио Тинто Групп (түүнийг төлөөлж ОТН болон АйВиЭн) нарын хооронд 2026 оны 5 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан Хэлэлцээний нэмэлт протоколын хүрээнд бусад аливаа эрхийг хөндөхгүй байх нөхцөлтэйгөөр 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Компанийн уурхайн ашиглалтын хугацаанд цаашид төлөх менежментийн нийт зардлыг (i) Менежментийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг бууруулах, (ii) үйл ажиллагааны менежментийн үйлчилгээний ажлын тодорхойлолтын хувьд төлбөр авахыг зогсоох, болон (iii) Төслийн санхүүжилттэй холбоотой зардлыг Менежментийн үйлчилгээний төлбөрийн тооцооллоос хасах замаар 50 хувиар бууруулахаар зарчмын хувьд тохиролцсон болно.

Иймд Талууд дээрх шийдвэрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор НӨОДТХНГ-ний 24.6 дахь заалтыг баримтлан энэхүү Гэрээг байгуулж, энэхүү Гэрээний 1.1, 1.2-д заасан нэмэлт, өөрчлөлтүүдийг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс (уг өдрийг оролцуулан), Гэрээний 1.3-1.7-д заасан нэмэлт, өөрчлөлтүүдийг 2026 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс (уг өдрийг оролцуулан), болон Гэрээний 1.8-д заасан нэмэлт өөрчлөлтийг энэхүү Гэрээ байгуулагдсан өдрөөс (уг өдрийг оролцуулан) тус тус дагаж мөрдөхөөр харилцан тохиролцов.

OYU TOLGOI LLC
ОЮУ ТОЛГОЙ ХХК
ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ
ХХК КОМПАНИ

БАТАЛГААТ ОРЧУУЛАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО
TRANSLATION BUREAU
ОРЧУУЛГЫН ТӨВЧОО
ТУС0084 302-2 8094918
ДИ ПИ ТРАНСЛЭЙШН БЮРО ХХК

1. НӨОДТХНГ-НД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1.1. НӨОДТХНГ-ний 7.4(в) заалтад дараах агуулга бүхий (iii) дахь хэсгийг шинээр нэмж оруулав. Үүнд:

"(iii) МҮТ-ийг шинэчлэх өдөр болон түүнээс хойшхи хугацааны хувьд гарсан Үндсэн хөрөнгийн зардал болон Үйл ажиллагааны зардлын (Төслийн санхүүжилтийн зардлыг оруулахгүйгээр) нийт дүнгийн 3.95% (гурван бүхэл зууны ерэн таван хувь),

байх бөгөөд 7.4(в)(ii) дах заалт нь МҮТ-ийг шинэчлэх өдөр хүртэл үйлчилнэ."

1.2. НӨОДТХНГ-ний 7.4 дэх заалтад дараах агуулга бүхий (ж), (з) заалтуудыг шинээр нэмж оруулав. Үүнд:

"(ж) МҮТ-ийг шинэчлэх өдөр болон түүнээс хойш Менежментийн баг болон түүний Хамаарал бүхий аливаа компани Компаниас менежментийн үйлчилгээний хүрээнд ажлын тодорхойлолтын аливаа төлбөрийг нэхэмжлэхгүй ба Компани ийм төлбөр төлөх үүрэг хүлээхгүй.

(з) Талууд, хамаарах тохиолдол болон хамаарах хүрээнд, Менежментийн үйлчилгээтэй холбоотойгоор Компанийн төлөх дүнг нягтлан бодох бүртгэлд хүлээн зөвшөөрөхөд холбогдох олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох татварын хууль тогтоомж үйлчлэх болохыг үүгээр тэмдэглэж байна. Ийнхүү тэмдэглэж буй нь холбогдох хүчин төгөлдөр стандарт болон хууль тогтоомж нь зөвхөн холбогдох хүрээ болон тохиолдлын хувьд хамаарах болохыг тусгах зорилготой бөгөөд Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу аль нэг Талын эдлэх эрх болон хүлээх үүргийг хөндөхгүй, тэдгээрт нөлөөлөх, тэдгээрийг хязгаарлах үндэслэл болохгүй."

1.3. НӨОДТХНГ-ний 11.3(д)(i) дах заалтад дараах агуулгатай (В) заалтыг шинээр нэмэв. Үүнд:

"(В) 13.3-д заасныг харгалзан, Хувь нийлүүлэгчийн зээлийн хүүгийн хувь өөрчлөгдөх өдрөөс хойших хугацаанд холбогдох Улирал тутамд Жишиг хүүгийн хувь дээр нэмэх нь 4.00% (дөрвөн хувь);

байх ба 11.3(д)(i)(Б) дах заалт нь Хувь нийлүүлэгчийн зээлийн хүүгийн хувь өөрчлөгдөх өдрийн өмнөх өдөр хүртэл үйлчилнэ."

Мөн 11.3(д)(i) дах заалтын төгсгөлд дараахийг нэмэв. Үүнд:

"Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, 11.3(д)(i)(В) заалтад заасан Жишиг хүүгийн хувь (холбогдох Улирлын) дээр 4.00 хувийг нэмсэн хүүгийн хувь хэмжээ нь жилийн бодит хүү байна."

1.4. НӨОДТХНГ-ний 11.3(ё) заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөв. Үүнд:

"(ё) Талууд Санхүүжилтийн хүүгийн хувь болон энэхүү Гэрээний 13.1(г)(iii)-д заасан, түүнчлэн Хувь нийлүүлэгчдийн одоогийн зээлийн тодорхойлолтод буй хүүгийн хувийн зохистой байдлыг Хувь нийлүүлэгчийн зээлийн хүүгийн хувь өөрчлөгдөх өдрөөс өмнө Хөрвүүлэх өдрөөс хойш 7 жил тутамд, Хувь

ОЮУ TOLGOI ЦС ХХК
ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК КОМПАНИ

БАТАЛГААТ ОРЧУУЛАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО
TRANSLATION BUREAU
ОРЧУУЛГЫН ТОВЧОО
ТУС0084 302-2 8094918
ДИ ПИ ТРАНСЛЭЙШН БЮРО ХХК

нийлүүлэгчийн зээлийн хүүгийн хувь өөрчлөгдөх өдрөөс хойш 3 жил тутамд хянан үзэх бөгөөд эдгээр хувийг бүх Талын зөвшөөрснөөр өөрчилж болно."

1.5. НӨОДТХНГ-ний 13.1(г) заалтад дараах агуулгатай шинэ (iii) заалтыг нэмэв. Үүнд:

"(iii) Хувь нийлүүлэгчийн зээлийн хүүгийн хувь өөрчлөгдөх өдрөөс хойших хугацаанд тухайн хуанлийн Улирал тутамд Жишиг хүүгийн хувь дээр нэмэх нь 4.00% (дөрвөн хувь);

байх ба 13.1(г)(ii) дах заалт нь Хувь нийлүүлэгчийн зээлийн хүүгийн хувь өөрчлөгдөх өдрийн өмнөх өдөр хүртэл үйлчилнэ."

Мөн 13.1(г) заалтын төгсгөлд дараахийг нэмэв. Үүнд:

"Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, 13.1(г)(iii) заалтад заасан Жишиг хүүгийн хувь (холбогдох Улирлын) дээр 4.00% (дөрвөн хувь)-ийг нэмсэн хүүгийн хувь хэмжээ нь жилийн бодит хүү байна."

1.6. НӨОДТХНГ-ний 13.4(а)(i)(А) заалтыг дор дурдсан агуулгаар өөрчлөв. Үүнд:

"*(А) Хувь нийлүүлэгчийн зээлийн хүүгийн хувь өөрчлөгдөх өдөр болон түүнээс хойшхи хугацаанд холбогдох Улирал тутамд 4.00% (дөрвөн хувь), болон*".

1.7. НӨОДТХНГ-ний 13.4(а)(i)(Б) заалтын төгсгөлд дараах өгүүлбэрийг нэмж оруулав. Үүнд:

"*Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс тодруулбал, 13.4(а)(i)(Б)-д тусгасан Хувь нийлүүлэгчийн санхүүжилтийн өртөг нь зөвхөн Төв банкны үйл ажиллагааны тасалдал үүссэн тохиолдолд СМЕ хугацаат SOFR-ыг тухайн хүүгийн хугацаанд ашиглах боломжгүй үед СМЕ хугацаат SOFR-ыг орлуулах зорилгоор ашиглагдах зорилготой бөгөөд 13.4(а)(i)-д тусгайлан заасан хүүгийн нэмэгдлээс бусад Хувь нийлүүлэгчийн зүгээс нэмж тооцох аливаа хүүгийн нэмэгдэл агуулаагүй болно.*"

1.8 НӨОДТХНГ-ний 25 дугаар зүйл (*Нэр томъёоны тодорхойлолт*)-д дараах шинэ тодорхойлолтуудыг цагаан толгойн дараалаар нэмэв. Үүнд:

""МҮТ-ийг шинэчлэх өдөр" гэж 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хэлнэ."

"Төслийн санхүүжилтийн зардал" гэж аливаа Төслийн санхүүжилттэй холбоотойгоор гарсан бүх өртөг, зардал, шимтгэл, хүү, төлбөр, түүний дотор Төслийн санхүүжилтийн хүүгийн төлбөр, амлалтын болон агентын хураамж, баталгааны шимтгэл болон холбогдох санхүүгийн болон бусад зөвлөх үйлчилгээний зардлыг хэлнэ."

"Хувь нийлүүлэгчийн зээлийн хүүгийн хувь өөрчлөгдөх өдөр" гэж 2026 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хэлнэ.""

2. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ БА БУЦААН ХЭРЭГЛЭХ

2.1. Гэрээний 2.2, 2.3 болон 2.4 дүгээр заалтыг харгалзан үзэж, энэхүү Гэрээ нь бүх Талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд НӨОДТХНГ-ний салшгүй хэсгийг бүрдүүлнэ. Энэхүү Гэрээгээр нэмэлт, өөрчлөлт

OYU TOLGOI LLC
ОЮУ ТОЛГОЙ ХХК

оруулаагүй НӨОДТХНГ-ний заалтууд нь аливаа өөрчлөлтгүйгээр хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

2.2. Энэхүү Гэрээний 1.1, 1.2-д заасан нэмэлт, өөрчлөлтийг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс (уг өдрийг оролцуулан), Гэрээний 1.3-1.7-д заасан нэмэлт, өөрчлөлтийг 2026 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс (уг өдрийг оролцуулан), Гэрээний 1.8-д заасан нэмэлт, өөрчлөлтийг энэхүү Гэрээ байгуулагдсан өдрөөс (уг өдрийг оролцуулан) эхлэн тус тус дагаж мөрдөнө.

2.3. 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс (уг өдрийг оролцуулан) энэхүү Гэрээг байгуулсан өдөр хүртэлх хугацаанд төлсөн буюу төлбөл зохих Менежментийн үйлчилгээний төлбөр болон менежментийн үйлчилгээтэй холбоотой бусад төлбөрийг энэхүү Гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулсан НӨОДТХНГ-нд нийцүүлэн энэхүү Гэрээг байгуулсан өдрөөс хойш Ажлын 30 (гуч) өдрийн дотор дахин тооцоолно. Тухайн хугацаанд илүү төлөгдсөн аливаа дүнг Менежментийн баг (эсхүл холбогдох төлбөрийг хүлээн авсан этгээд) Компанид нэн даруй буцаан төлөх, эсхүл Компанийн сонголтоор дараагийн төлбөл зохих Менежментийн үйлчилгээний төлбөрөөс суутган тооцно.

2.4. 2026 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс (уг өдрийг оролцуулан) энэхүү Гэрээг байгуулсан өдөр хүртэлх хугацаанд төлсөн буюу төлбөл зохих Хувь нийлүүлэгчийн өрийн хүүтэй холбоотой аливаа төлбөрийг энэхүү Гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулсан НӨОДТХНГ-нд нийцүүлэн Гэрээ байгуулсан өдрөөс хойш Ажлын 30 (гуч) өдрийн дотор дахин тооцоолно. Тухайн хугацаанд илүү төлөгдсөн аливаа дүнг төлбөрийг хүлээн авсан этгээд Компанид нэн даруй буцаан төлөх, эсхүл Компанийн сонголтоор дараагийн төлбөрөөс суутган тооцно.

3. БУСАД ЗААЛТ

3.1. Энэхүү Гэрээ болон түүнээс үүсэх, эсхүл түүнтэй холбоотойгоор үүсэх аливаа гэрээний бус үүргийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулж, тайлбарлана.

3.2. Энэхүү Гэрээг хэд хэдэн хувь үйлдэж болох бөгөөд тэдгээр нь Талууд Гэрээний нэг хувь дээр гарын үсэг зурсантай адил хүчин төгөлдөр байна.

3.3. НӨОДТХНГ-ний 24.1 (*Мэдэгдэл*), 24.8 (*Хэл*) болон 23 (*Маргаан шийдвэрлэх*) заалтуудыг mutatis mutandis байдлаар тусгасан гэж үзэх бөгөөд тэдгээр зүйл заалтуудын агуулга үл өөрчлөгдөнө.

3.4. Тухайн утгаас нь хамааран өөрөөр тайлбарлахаас бусад тохиолдолд НӨОДТХНГ (энэхүү Гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулсан)-нд тодорхойлсон эсхүл хэрэглэсэн аливаа нэр томьёо нь энэхүү Гэрээнд мөн адил утгатай байна. НӨОДТХНГ-г энэхүү Гэрээтэй хамтад нь нэг баримт бичиг байдлаар ойлгож, тайлбарлана.

ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ХУУДАС

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК

Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийг төлөөлж, гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан _____:

_____

Гарын үсэг

Б. ТЭЛМҮҮН

Албан тушаал ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ТИ ЭЙЧ АР ОЮУ ТОЛГОЙ ЛТД

Ти Эйч Ар Оюу Толгой Лтд-ийг төлөөлж, гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан _____:

_____

Гарын үсэг

МАЙК ПАСМОР

Албан тушаал ЗАХИРАЛ

ОЮУ ТОЛГОЙ НИДЕРЛАНД БИ.ВИ

Оюу Толгой Нидерланд Би.Ви-ийг төлөөлж, гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан _____:

_____

Гарын үсэг

ЖОН КИДД

Албан тушаал ЗАХИРАЛ

Оюу Толгой Нидерланд Би.Ви-ийг төлөөлж, гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан _____:

_____

Гарын үсэг

ФРАНК ШАУВЕРТ

Албан тушаал ЗАХИРАЛ

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Оюу Толгой ХХК-ийг төлөөлж, гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан _____:

_____

Гарын үсэг

С. МӨНХСҮХ

Албан тушаал ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ